



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
Т У Ш А А Л

2000 оны 1 сарын 05 өдөр

Дугаар 9

Улаанбаатар-11

Зөвлөмж батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1."Банкны хүүгийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх зөвлөмж"-ийг хавсралтаар баталсугай.


2.Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон сургалтыг 2000 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулахыг Хяналт шалгалтын газар (Д.Энхжаргал), банкуудын Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлуудад даалгасугай.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.



Ж.ҮНЭНБАТ

**ХҮҮГИЙН ЭРСДЛИЙН УДИРДАГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**



НЭГ.Нийтлэг үндэслэл

1.Хүүгийн эрсдлийн удирдлагыг тавихад Монголбанк, банкны Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, Актив пассивын удирдлагын хороо, дотоод хяналтын алба, аудитын байгууллагын хүлээх эрх үүргийг тодорхойлоход энэхүү зөвлөмжийн зорилго оршино.

ХОЁР.Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх үүрэг

2.Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь дараахь эрх үүрэгтэй байна:

- 2.1.Банкны Актив пассивын удирдлагын хорооны гишүүдийг томилох,
- 2.2.Банкны Актив пассивын удирдлагын хорооноос боловсруулсан хүүгийн эрсдлийн удирдлагын журмыг батлах,
- 2.3.Дотоод хяналтын албанаас хүүгийн эрсдлийн удирдлагад хийсэн шалгалтын акт, материалыг хэлэлцэж, батлах,
- 2.4.Актив пассивын удирдлагын хорооноос ирүүлсэн тайлан мэдээтэй танилцаж, шаардлагатай гэж үзвэл хүүгийн эрсдлийн удирдлагын журамд нэмэлт, өөрчлөлт оруулах.

ГУРАВ.Банкны Актив пассивын удирдлагын хороо

3.Дараахь албан тушаалтан болон газар, хэлтсийн захирлууд нь банкны Актив пассивын удирдлагын хорооны гишүүд байна:

- 3.1.Гүйцэтгэх захирал
- 3.2.Дэд захирал
- 3.3.Бүртгэл тооцооны асуудал эрхлэсэн захирал
- 3.4.Хөрөнгө оруулалтын асуудал эрхлэсэн захирал
- 3.5.Зээлийн асуудал эрхлэсэн захирал
- 3.6.Эх үүсвэр төлөвлөлтийн асуудал эрхлэсэн захирал
- 3.7.Бусад

4.Актив пассивын удирдлагын хороо нь дараахь эрх үүрэгтэй байна:

3.6. Эх үүсвэр төлөвлөлтийн асуудал эрхэлсэн захирал;

3.7. Бусад.

4. Актив пассивын удирдлагын хороо нь дараахь эрх үүрэгтэй байна:

4.1. Хүүгийн эрсдэлийн удирдлагын журмыг боловсруулж, ТУЗ-өөр батлуулах, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ТУЗ-д танилцуулах, (энэ журамд хүүгийн эрсдэлийг тодорхойлох аргачлал, хүүгийн эрсдэлийн мэдээллийн механизм, хүүгийн эрсдэлийг бууруулах арга зам, дотоод хяналтын албанаас хяналт тавих, шалгалт хийх журам, хүүгийн эрсдэлийн чиглэлээр шалгалт хийхэд аудитын байгууллага /аудитор/-ыг оролцуулах журам болон ажиллагсадын ажил үүргийн хуваарь зэргийг тусгасан байна),

4.2. Банкны хүүгийн эрсдэлийн түвшин, түүнийг зохистой удирдах талаар авсан арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн талаарх тайланг жилд 2-оос доошгүй удаа ТУЗ-д танилцуулах,

4.3. Хүүгийн эрсдэлийг агуулж байдаг тодорхой чиглэлийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох,

4.4. Хүүгийн эрсдэлийг бууруулах талаар авч болох арга хэмжээний хувилбаруудаас сонголт хийх, тухайлбал, фьючерс, опцион, хүүгийн своп, кэп, флор, коридор зэрэг хэлцлүүдийг ашигласан аргуудаас аль нэгийг сонгох, эсвэл тэдгээрийг хослуулан хэрэглэх.

4.5. ТУЗ, Актив пассивын удирдлагын хороо, газар, хэлтсийн захирлуудад хүүгийн эрсдэлийн талаар мэдээлэх тайлангийн маягтыг батлах, тухайн тайланг гаргах давтамжийг тодорхойлох,

4.6. Хүүгийн эрсдэлийн удирдлагын журмын дагуу ажил үүрэг тус бүрээр хариуцсан ажилтанг тусгайлан томилох,

4.7. Банкны хүүгийн эрсдэлийн түвшинг энэ зөвлөмжийн хавсралтад заасан аргачлалын дагуу тодорхойлж болно.

ДӨРӨВ. Дотоод хяналтын албаны эрх үүрэг

5. Банкны Дотоод хяналтын алба нь хүүгийн эрсдэлийн чиглэлээр жилд нэгээс доошгүй удаа шалгалт хийж, шалгалтын акт материалыг ТУЗ-д танилцуулна.

6. Шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчил гаргасан

ажилтанд хариуцлага ногдуулахад үүсэх харилцааг Банкны тухай хууль болон түүнтэй холбогдсон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

ТАВ. Монголбанкны хяналт

7.Банк нь хүүгийн эрсдэлийн удирдлагын журмыг гарган мөрдөж байгаа эсэхэд хяналт тавина.

ЗУРГАА. Хөндлөнгийн хяналт

10.Аудитын байгууллага /аудитор/ нь банкны санхүүгийн тайлан, баримт материалын талаархи дүгнэлтэд хүүгийн эрсдэлийн түвшингийн талаар тусгасан байна.

11.ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл хүүгийн эрсдэлийн чиглэлээр хийх дотоод хяналтын албаны шалгалтад аудитын байгууллага /аудитор/-ыг гэрээгээр оролцуулж болно.

*Хүүгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
зөвлөмжийн хавсралт*

**БАНКНЫ ХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН ТҮВШИНГ
ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ**

НЭГ. Хүүгийн мэдрэмжийн зөрүү (GAP) гэж хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий пассивын зөрүүг хэлнэ.

Gap	=	Хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий актив	-	Хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий пассив
-----	---	--	---	---

Хүүгийн мэдрэмжийн зөрүүг мөн харьцангуй хэмжигдэхүүнээр тодорхойлж болно

Gap	=	Хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий актив	
		Хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий пассив	

1.1. Хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий актив гэдэгт дараахь активыг хамруулан ойлгоно:

- а. Зээл
- б. Үнэт цаас
- в. Бусад

Хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий пассивт дараахь пассивыг оруулна:

- а. Хүү хуримтлуулан тооцдог харилцах
- б. Хадгаламж
- в. Хадгаламжийн сертификат
- г. Банкнаас гаргасан бусад өрийн бичиг
- д. Бусад банкнаас авсан зээл

е. Бусад

1.2 n үеийн өсөн нэмэгдэх зөрүү (CG) гэж n, n-1, n-2. . . 1 үед хамаарах хүүгийн мэдрэмжийн зөрүүний нийлбэрийг хэлнэ.

$$CG_n = \sum_{i=1}^n Gap_i = Gap_1 + Gap_2 + \dots + Gap_n$$

1.3. Хүүгийн цэвэр орлогын харьцаа (NIM) гэж хүүгийн орлого болон хүүгийн зарлагын зөрүүг орлого авчирдаг активт харьцуулсан харьцааг хэлнэ.

NIM	=	Хүүгийн орлого – Хүүгийн зарлага	
		Орлого авчирдаг актив	

1.4. Хүүгийн цэвэр орлогын өөрчлөлт (NII)

$$\Delta NII = \Delta k * CG$$

ΔNII - Хүүгийн цэвэр орлогын өөрчлөлт

Δk - хүүгийн өөрчлөлт

ХОЁР. Эргэн төлөгдөх дундаж хугацаа (Duration) гэж тухайн хөрөнгө буюу тухайн өр төлбөрийн төлөгдөх хугацааг тэдгээрийн ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр жигнэж тооцсон дундаж хугацааг хэлнэ.

$$Duration = \frac{\sum_{t=1}^n \frac{C_t}{(1+i)^t} \times t}{\sum_{t=1}^n \frac{C_t}{(1+i)^t}} = \frac{\frac{C_1}{(1+i)^1} + \frac{C_2}{(1+i)^2} \times 2 + \dots + \frac{C_n}{(1+i)^n} \times n}{\frac{C_1}{(1+i)^1} + \frac{C_2}{(1+i)^2} + \dots + \frac{C_n}{(1+i)^n}}$$

C_t - t үед гарах мөнгөний урсгалын дүн

i - хүүгийн хувь

2.1. Нийт актив болон нийт пассивын дундаж хугацаа:

$$D_A = \frac{\sum_{i=1}^n A_i \times Duration_i}{TA}$$

D_A - нийт пассивын дундаж хугацаа

A_i - i -р төрлийн активын хувийн жин

$Duration_i$ - i -р төрлийн активын эргэн төлөгдөх дундаж хугацаа

TA - хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий актив.

$$D_L = \frac{\sum_{i=1}^n L_i \times Duration_i}{TL}$$

D_L - нийт пассивын дундаж хугацаа

L_i - i -р төрлийн пассивын хувийн жин

$Duration_i$ - i -р төрлийн пассивын эргэн төлөгдөх дундаж хугацаа

TL - хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий нийт пассив

2.2. Дундаж хугацааны зөрүү:

$$\text{Duration}$$
$$\text{disbalance} = DD = D_A - D_L \times \frac{TL}{TA}$$

ГУРАВ. Зохистой харьцаа

Банкны хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий нийт актив пассивын зөрүү банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байвал зохистой.

$$\frac{CG}{CA} \times 100\% < 20\%$$

Үүнд CA нь банкны өөрийн хөрөнгө

3.2. Банкны нийт актив, пассивын дундаж хугацааны зөрүү нь нийт активын дундаж хугацааны 30 хувиас хэтрэхгүй байвал зохистой.

$$\frac{DD}{D_A} \times 100\% < 30\%$$